



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/04

Онги

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Найз багийн нутаг "Галт хайрхан" /N45.677493/ /E104.033124/ гэх газарт 2023 оны 01 сарын 14-ний өдөр малын гоц халдварт бог малын мялзан өвчин оношлогдсон тул хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Хорио цээрийн дэглэм тогтоосон өвчний голомттой бүс нутгаас мал шилжүүлэх, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглосугай.

3. Голомтын бүс нутгийн мал сүрэгт эмнэлзүйн үзлэг, ариутгал халдваргүйтгэл, эмчилгээ хийж ажиллахыг "Онги таван эрдэнэ" мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн малын эмч (Б.Цэнгэлмаа), мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч эмч (Г.Дэлгэрмаа ) нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ард иргэд, малчдыг малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагч (Ц.Саранчимэг), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМАРСАНАА